



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/11

Улаан-уул

「Мал, амьтныг шимэгчтэх өвчнийг эмчлэх,  
урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны  
төлөвлөгөөг батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Мал, амьтны шимэгчтэх өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоон төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 03 сарын 10-ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны  
өдрийн 06/11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

МАЛ АМЬТНЫ ШИМЭГЧТЭХ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭН  
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
1		3	4	5	6	7	8	9
<b>Зорилго. Мал эмнэлгийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд чанартай хэрэгжүүлэх, орон нутагт мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд оршино.</b>								
	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.11.4 дэхь заалт, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.5 дахь заалт	1.1 Баг бүрт мал угаалгын ажиллагааг зохион байгуулж малчдын идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх 1.2 Туулгалтанд мал сургийг технологит хугацаанд нохой, муурыг улирал хамруулан ажиллах	Малчин	7100 бод, 110016 бог малд угаалгын ажлыг хийх	2021 онд угаалганд нийт 7134 мал хамруулсан.	Мал угаалгын ажилд төлөвлөгөөт мал сургийг бүрэн хамруулж мэдээ тайланг тайлагнасан байна.	7-9 сар /3-р улирал/	Мал эмнэлгийн тасаг, Гэрээт МЭҮН-үүд
1.		1.3 Боловсруулалтанд бод бог малыг бүрэн хамруулан ажиллах	Малчин	6100 бод, 105516 бог, нохой муур 410 мал амьтдыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдана.	2021 онд туулгалтанд нийт 58225 мал амьтан хамрагдсан. Үүнээс нохой-364 бог мал-43574 үйлчилгээд хамрагдсан.	Мал, амьтныг цаг хугацаанд нь туулгаснаар малын ашиг шим сайжирч дотор шимэгтчэх өвчний өвчлөл, халдварлалт багасна	2, 3-р улирал	Мал эмнэлгийн тасаг, Гэрээт МЭҮН-үүд
				7100 бод, 88516 бог малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулна.	2021 онд боловсруулалтанд 5390 үхэр үйлчилгээнд хамруулсан.	- Төлөвлөгөөт мал сургийг бүрэн хамруулсан байна. - Шимэгтчэх өвчний халдварлалтыг бууруулна. - Малын тарга хүч сайжирна.	4-5 сард 9-10 сард	Мал эмнэлгийн тасаг, Гэрээт МЭҮН-үүд

2.


1	2	3	4	5	6	7	8	9
		1.4 Хөрш айлын ахлагч малчид хөрш айлынхаа өвөлжөө, хаваржааны бууцыг хавар эрт сийрүүлж, орчны хог хаягдал, үс ноосыг цэвэрлэж халдваргүйтгэл хийхэд бэлтгэх	ОНХС 10.0 сая Малчин	Малчид цэвэрлэгээ хийж бууцаа сийрүүлснээр	Малчид хаваржааныхаа бууцыг аажуу сийрүүлдэг энэ нь халдваргүйтгэл үр дүнгүй болох нэг шалтгаан болдог	Бууцаа хавар эрт сийрүүлж орчны цэвэрлэгээ хийснээр халдваргүйтгэлийн төлөвлөгөөт арга хэмжээ цаг хугацаандаа хийгдэх боломж нөхцөл бүрдэнэ.	4-5 сар 9-10 сар	МЭТ, ХААТ, БЗД нар
		1.5 Газар эзэмшлийн гэрчилгээ бүхий өвөлжөө хаваржааны хашаа хороог халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах		Сумын нийт өвөлжөө хаваржааны нарийвчилсан судалгааг гаргаснаар	2021 онд 240 н хашаа хорооны 14000 мкв талбайг халдваргүйжүүлсэн	Сумын нийт өвөлжөө хавалжааны хашаа хороог халдваргүйжүүлэн үр дүнг тооцон тайлагнасан байна.	2, 3-р улиралд	ЗДТГ, МЭҮН
		1.6 Сумын нийт худаг уст цэгийг халдваргүйжүүлэх		52 худгийн 13100 мкв талбайг хамруулан халдваргүйжүүлнэ.	2021 онд 9-н худгийн 200 мкв талбайг халдваргүйжүүлсэн.	Хүн малын үндны усны эрүүл ахуйн ариун цэврийг сайжруулан малын халдварт, шимэгчтэх өвчин дамжих эрсдлийг бууруулна.		
		1.7 Малын гоц халдварт, өвчин үед гарсан шаардлагатай бэлчээрийн талбайд халдваргүйжүүлэлт хийх		Шаардлагатай үед халваргүйтгэл хийснээр	2021 онд 8000 мкв талбайг халдваргүйжүүлт хийсэн.		5 сард	Гэрээт МЭҮН-үүд
		1.8 Халдваргүйтгэлийн зориулалттай автомашинтай болох	ОНХС 42.0 сая	Машинтай болсноор	МЭҮН-үүдэд бүртгэлтэй помп, автомакс зэргийг ашиглаж ирсэн хүртээмж муу байсан.	Сумын нийт өвөлжөө хаваржаа, худаг уст цэгийг халдваргүйжүүлж малын халдварт, шимэгчтэх өвчин гарах эрсдлийг бууруулна.	2, 3 дугаар улиралд	ЗДТГ

3.

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>1.9 Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах</p>	<p>ААН</p>	<p>Помп, мотор, тонны сав, туулганы сав, автомат тариур багуудад байгаа угаалгын ванныг цэвэрлэх, ашиглах</p>	<p>Бурхант 1-р багийн мал угаалгын суурин ванныг багийн Засаг дарга, малчдын идэвх бүлгийн мал санаачлагаар хамтран мал угаалгын ажлыг үр дүнтэй зохион байгуулсан. Мөн ААН-ын эмч нар шурших аргаар угаалгын ажлыг хэрэгжүүлсэн.</p>	<p>ААН-үүд Помп, мотор, тонны сав, туулганы сав, автомат тариур техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлаа бүрэн хангаснаар үйл ажиллагаа саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p>	<p>2, 3-р улиралд</p>	<p>МЭҮН-үүд</p>
<p>2. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.11.1 Дэхь заалт</p>	<p>2.1 Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай хүргэхэд хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах</p> <p>2.1 Өтөг бууцыг биотермийн аргаар халдваргүйжүүлэх зөвлөмж болон шимэгчтэх өвчний арга хэмжээнд хэрэглэж буй эм бэлдмэлийн зохистой хэрэглээний талаар сургалт сурталчилгааг хүргэх</p>			<p>Гэрээт МЭҮН-үүдэд хяналт тавьж ажилласнаар</p>	<p>Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн хяналт 30%-д тавьсан</p>	<p>Шимэгчтэх урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээний чанар сайжирч төлөвлөгөөт тоог бүрэн биелүүлсэнд хяналт тавих</p>	<p>2, 3-р улирал</p>	<p>Мал эмнэлгийн тасаг</p>
				<p>Сургалт сурталчилгааг нийт малчин өрхөд хүргэснээр</p>	<p>Халдваргүйтгэл хийх заавар малчдад зориулсан гарын авлага 350 малчин өрхөд хүргэсэн.</p>	<p>Малын эм бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж малын эмчийн заавар дагуу зөвлөмжийн хэрэглэж хэвшсэн байна.</p>	<p>1, 2, 3-р улиралд</p>	<p>МЭТ, МЭҮН</p>

---000---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны  
өдрийн 06/11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТООН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Угаалга			Туулгалт				ИвOMEкийн боловсруулалт			Нийт дүн
			Бод	Бог	Бүгд	Бод	Бог	Амьтан	Бүгд	Бод	Бог	Бүгд	
1		Түйн дэлгэрэх хоршоо	1300	25000	26300	1300	25000	60	26360	1300	25000	26300	78960
2		ДЭНЗӨ ХХК		4000	4000	1000	4000	30	5030	1000	2000	3000	12030
3	Өлзийт	Эх тал газар ХХК	3000	19500	22500	2000	15000	200	17200	2000		2000	41700
4		Түмэн сүргийн хишиг ХХК	2800	61516	64316	1800	61516	120	63436	2800	61516	64316	192068
		<b>Нийт</b>	<b>7100</b>	<b>110016</b>	<b>117116</b>	<b>6100</b>	<b>105516</b>	<b>410</b>	<b>112026</b>	<b>7100</b>	<b>88516</b>	<b>95616</b>	<b>324758</b>

---000---